



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/61/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)  
Аудитор Ч.Анхбаяр  
Утас: 8511-6555  
Цахим хаяг: [Ankha964@gmail.com](mailto:Ankha964@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.	
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.5.3 Нэмэлт төсөв.....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	17
5.1 Төлбөрийн акт.....	
5.2 Албан шаардлага.....	
5.3 Зөвлөмж.....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.13 № 118

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хязгаарлалттай дүгнэлт

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Г.ДЭЛГЭРДАЛАЙ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэмандал сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Анхан шатны баримтгүйгээр 10000.0 мянган төгрөгийг хувь хүнд шилжүүлж бараа материалын орлого, зардлаар бүртгэж тайлагнасан
- Үндэслэх анхан шатны баримтгүй нийт 25127.2 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн
- Эд хариуцагч нь бараа материалын нэр төрлийн тайланг бэлтгээгүй, хүнс, хоол, бусад бараа үйлчилгээний материалд 37356.7 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан
- Ажилтнуудын ажлын үр дүнгийн урамшууллыг сар болгон тооцож, улирал тутам олгохоор зохицуулсан Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу улирлаар олгоогүй, сараар олгосон
- Аудитад шаардагдах баримт материалыг дурьдсан хугацаанд ирүүлээгүй, удаа дараа шаардуулж, шаардлага хангахгүй, бүрдэл дутуу анхан шатны баримт, материал ирүүлж аудитын үйл ажиллагаанд саад учруулан, аудитын дүгнэлт гаргах хуулийн хугацааг хоцроосон;

Эдгээр зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1, Төсвийн тухай хуулийн 6.4.1, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "журмын 3.2, 3.6, Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.6, 3.7, 3.8, 3.9 дэх заалтуудыг зөрчсөн. Эдгээр зөрчил нь бидний тооцсон материаллагийн хэмжээнээс хэтэрсэн бөгөөд аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хийсэн гол шинэчлэлийн үр дүнд эмнэлгүүдийг орцоор санхүүжүүлэхийг бүрэн зогсоож, үзүүлсэн тусламж, үйлчилгээний тохиолдлоор буюу гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна. "Нарийн зураа" ХХК-д өмнөх оны жилийн эцэст 18,838.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл бүртгэгдэж, баталгаажсаныг тайлангийн жилд "Бөмбөө зайсан" хоршоонд шилжүүлж өр төлбөр барагдуулсан байна. Тайлангийн жилд уг ААН-ийн борлуулалт болон эрүүл мэндийн төвийн худалдан авалт баримтаар нотлогдоогүй тул нийт 131.8 сая төгрөгийн худалдан авалт, борлуулалтыг аймгийн Татварын хэлтсээр нягтлуулахаар шилжүүллээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 үндсэн зорилго, 4 зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын засаг дарга 95 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	131,898,737.00	32,563,400.15
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,248,062.21	2,869,600.00
3121	Төгрөг	5,248,062.21	2,869,600.00
31211	Төрийн сангийн харилцах	5,248,062.21	2,869,600.00
33	АВЛАГА	105,162,000.00	-
33300	Татаас санхүүжилтийн авлага	105,162,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	21,488,674.79	29,693,800.15
35100	Түүхий эд материал	18,777,274.79	25,933,780.15
35130	Эм боох материал	18,777,274.79	25,933,780.15
35400	Хангамжийн материал	2,711,400.00	3,760,020.00
35420	Түлш шатах тослох материал	1,002,150.00	1,868,020.00
35430	Хүнсний материал	1,709,250.00	1,892,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,008,027,345.97	1,162,047,765.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,008,027,345.97	1,162,047,765.29
39200	Биет хөрөнгө	975,509,345.97	1,129,529,765.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	973,771,169.30	1,069,773,108.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 138,594,901.78	- 153,750,985.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	76,799,260.00	76,799,260.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 51,184,876.84	- 63,231,395.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	313,573,858.31	416,807,834.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 206,062,951.30	- 222,517,958.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,887,751.00	29,887,751.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 22,679,962.72	- 24,237,848.76
39300	Биет бус хөрөнгө	32,518,000.00	32,518,000.00
39301	Програм хангамж		
39303	Бусад биет бус хөрөнгө	32,518,000.00	32,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,139,926,082.97	1,194,611,165.44
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	100,546,000.00	
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,546,000.00	
413	Өглөг	100,546,000.00	
413101	Ажиллагчидтай холбогдсон өглөг	81,707,400.00	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,838,600.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,039,380,082.97	1,194,611,165.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,039,380,082.97	1,194,611,165.44
51100	Засгийн газрын оруулсан капитал	727,738,725.60	727,738,725.60
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	727,738,725.60	727,738,725.60
51200	Хуримтлагдсан үр дүн	- 203,763,558.12	- 48,532,475.65
51210	Өмнөх үеийн үр дүн	- 203,763,558.12	- 203,763,558.12
51220	Тайлант үеийн үр дүн		155,231,082.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	515,404,915.49	515,404,915.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,139,926,082.97	1,194,611,165.44

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
-----	----------	----------	------------

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЭМТ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,569,298,453.01	1,396,519,368.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	397,049,801.01	267,770,378.99
120	Нийтлэг татварын бус орлого	397,049,801.01	267,770,378.99
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	64,919,573.00	186,235,915.02
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	332,130,228.01	81,534,463.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	510,179,252.00	1,128,748,990.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	662,069,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	359,195,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359,195,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,061,400.00	126,448,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,061,400.00	126,448,800.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	129,922,652.00	1,002,300,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	129,922,652.00	1,002,300,190.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,534,859,553.75	1,241,288,286.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,534,859,553.75	1,241,288,286.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,483,059,553.75	1,241,288,286.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	736,831,877.03	558,574,230.56
210101	Үндсэн цалин	317,994,782.00	376,881,028.00
210102	Нэмэгдэл цалин	365,791,805.03	135,245,634.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт		22,000.00
210104	Урамшуулал	53,045,290.00	46,425,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,396,078.76	91,830,369.44
210201	Тэтгэврийн даатгал	55,124,150.99	69,685,269.44
210202	Тэтгэмжийн даатгал	9,345,636.10	5,536,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,351,321.86	4,429,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,052,269.93	1,107,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,522,699.88	11,072,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,204,712.00	118,864,800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,820,112.00	8,160,000.00
210302	Түлш, халаалт	14,160,000.00	110,404,800.00
210303	Цэвэр, бохир ус	224,600.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,310,472.00	65,386,434.00
210401	Бичиг хэрэг	3,672,100.00	8,522,470.00
210402	Тээвэр, шатахуун	28,187,022.00	25,801,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,325,800.00	9,224,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	964,329.00	2,467,414.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,161,221.00	19,370,500.00
	Нормативт зардал	549,612,965.01	287,580,271.82
210501	Эм	439,312,827.01	213,576,121.82
210502	Хоол	110,135,138.00	66,044,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	165,000.00	7,960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,316,600.00	17,686,010.00
210601	Багаж хэрэгсэл	1,681,600.00	5,407,010.00
210604	Урсгал засвар	1,635,000.00	12,279,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,339,700.00	2,446,000.00
210702	Дотоод албан томилолт	3,339,700.00	2,446,000.00

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЭМТ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,120,000.00	837,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар		313,500.00
2109	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	524,000.00
220103	Бараа үйлчилгээний бусад зардал	38,927,148.95	98,082,670.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,505,300.00	52,867,175.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,421,848.95	45,215,495.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,800,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,800,000.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,800,000.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	34,438,899.26	155,231,082.47
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	34,438,899.26	155,231,082.47

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,067,086,652.00	1,233,910,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,067,086,652.00	1,233,910,990.00
131007		662,069,400.00	
	Нэмэлт санхүүжилтийн орлого	359,195,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359,195,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,061,400.00	126,448,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,061,400.00	126,448,800.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,760,652.00	1,107,462,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,760,652.00	1,107,462,190.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,061,838,589.79	1,223,289,452.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,061,838,589.79	1,223,289,452.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,038,589.79	1,223,289,452.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	655,124,477.03	640,281,630.56
210101	Үндсэн цалин	317,994,782.00	376,965,369.00
210102	Нэмэгдэл	284,084,405.03	216,868,693.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт		22,000.00
210104	Урамшуулал	53,045,290.00	46,425,568.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,396,078.76	91,830,369.44
210201	Тэтгэврийн даатгал	55,124,150.99	69,685,269.44
210202	Тэтгэмжийн даатгал	9,345,636.10	5,536,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,351,321.86	4,429,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,052,269.93	1,107,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,522,699.88	11,072,500.00

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЭМТ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,304,712.00	118,864,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,520,112.00	8,160,000.00
210302	Түлш, халаалт	14,560,000.00	110,404,800.00
210303	Цэвэр, бохир ус	224,600.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,760,100.00	67,032,534.00
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	10,682,100.00
210402	Тээвэр, шатахуун	26,300,000.00	25,534,734.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,132,200.00	8,392,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,477,900.00	3,225,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,550,000.00	19,198,600.00
2105	Нормативт зардал	183,677,550.00	230,007,608.21
210501	Эм	99,600,050.00	143,310,008.21
210502	Хоол	83,912,500.00	78,737,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	165,000.00	7,960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,235,972.00	17,686,010.00
210601	Багаж техник хэргэсэл	4,600,972.00	5,407,010.00
210604	Урсгал засвар	1,635,000.00	12,279,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,339,700.00	2,446,000.00
210702	Дотоод албан томилолт	3,339,700.00	2,446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	837,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	313,500.00
2109	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	524,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,000,000.00	54,303,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,800,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,800,000.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	51,800,000.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,248,062.21	10,621,537.79
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		13,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		13,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		13,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		13,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	5,248,062.21	2,869,600.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	203,763,558.12	1,039,380,082.97
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	203,763,558.12	1,039,380,082.97
9	Тайлант үеийн үр дүн			155,231,082.47	155,231,082.47
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	727,738,725.60	515,404,915.49	48,532,475.65	1,194,611,165.44

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,248,062.21	5,248,062.21	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,224,875,000.00	1,236,289,452.21	11,414,452.21	100.90%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,224,875,000.00	1,236,289,452.21	11,414,452.21	100.90%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,224,875,000.00	1,236,289,452.21	11,414,452.21	100.90%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	611,600,000.00	640,281,630.56	28,681,630.56	104.70%
210101	Үндсэн цалин	361,130,100.00	376,965,369.00	15,835,269.00	104.40%
210102	Нэмэгдэл	174,460,700.00	216,868,693.56	42,407,993.56	124.30%
210103	Унаа, болон бусад нөхөн олговор		22,000.00	22,000.00	
210104	Урамшуулал	76,009,200.00	45,425,568.00	29,583,632.00	61.10%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,410,200.00	91,830,369.44	3,420,169.44	103.90%
210201	Тэтгэврийн даатгал	66,265,100.00	69,685,269.44	3,420,169.44	105.20%
210202	Тэтгэмжийн даатгал	5,536,300.00	5,536,300.00		100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,429,000.00	4,429,000.00		100%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,107,300.00	1,107,300.00		100%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,072,500.00	11,072,500.00		100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,365,700.00	118,864,800.00	19,500,900.00	85.90%
210301	Гэрэл, цахилгаан	6,885,000.00	8,160,000.00	1,275,000.00	118.50%
210302	Түлш, халаалт	131,105,700.00	110,404,800.00	20,700,900.00	84.20%
210303	Цэвэр, бохир ус	375,000.00	300,000.00	75,000.00	80%

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЭМТ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	69,397,500.00	67,032,534.00	2,364,966.00	96.60%
210401	Бичиг хэрэг	10,682,100.00	10,682,100.00		100%
210402	Тээвэр, шатахуун	27,899,600.00	25,534,734.00	2,364,886.00	91.50%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,392,200.00	8,392,100.00	100.00	100%
210404	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,225,000.00	3,225,000.00		100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,198,600.00	19,198,600.00		100%
2105	Нормативт зардал	207,758,700.00	230,007,608.21	22,248,908.21	110.70%
210501	Эм	158,061,200.00	143,310,008.21	14,751,191.79	90.70%
210502	Хоол	41,737,500.00	78,737,600.00	37,000,100.00	188.60%
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	7,960,000.00	7,960,000.00		100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,766,300.00	30,686,010.00	15,080,290.00	67%
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,487,300.00	18,407,010.00	10,080,290.00	64.60%
210604	Урсгал засвар	17,279,000.00	12,279,000.00	5,000,000.00	71.10%
2107	Томилолт, зочны зардал	6,600,000.00	2,446,000.00	4,154,000.00	37.10%
210702	Дотоод албан томилолт	6,600,000.00	2,446,000.00	4,154,000.00	37.10%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,673,600.00	837,500.00	1,836,100.00	31.30%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	537,600.00		537,600.00	
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00		210,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	313,500.00	313,500.00		100%
210805	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,612,500.00	524,000.00	1,088,500.00	32.50%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,303,000.00	54,303,000.00		100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,303,000.00	54,303,000.00		100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,157,461,300.00	1,233,910,990.00	76,449,690.00	106.60%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	83,536,000.00	126,448,800.00	42,912,800.00	151.40%
320001	Орон нутгийн төсвөөс	83,536,000.00	126,448,800.00	42,912,800.00	151.40%
	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	932,450,100.00	1,107,462,190.00	175,012,090.00	118,8%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	932,450,100.00	1,107,462,190.00	175,012,090.00	118,8%
	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,475,200.00		141,475,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,475,200.00		141,475,200.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,248,062.21	5,248,062.21	

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын ЭМТ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,869,600.00	2,869,600.00	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1			
610001	Төсвийн байгууллага	1	1			
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	37			100%
620001	Удирдах ажилтан	1	1			100
620002	Гүйцэтгэх ажилтан	25	24	1		96%
620003	Үйлчлэх ажилтан	11	12	-1		109.10%

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,162,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,162,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,162,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	28,681,630.56
210101	Үндсэн цалин	3,981,722.00
210102	Нэмэгдэл хөлс	24,699,908.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,480,369.44
210201	Тэтгэврийн даатгал	22,480,369.44
2104	Хангамж, бараа материалын зардал	2,000,000.00
210402	Тээвэр шатахуун	2,000,000.00
2105	Норматив зардал	52,000,000.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,000,000.00
210502	Хоол, хүнс	37,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	105,162,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,162,000.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй, нийт 114.763.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 36,617.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх 4 төлбөрийн акт тогтоож, 59,307.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж, нягтлан бодогч, нярав нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Байгууллагын төсвөөс 24 ажилтанд 590.0 мянган төгрөгөөр биеийн тамирын хувцас худалдан авч үнэ төлбөргүй олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1."Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:"4.1.3.үр ашигтай байх;" Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.1.2 Хувь хүнд хайсны төмөр худалдан авахаар 10000.0 мянган төгрөг шилжүүлснийг тухайн материалыг хүлээн аваагүй байхад орлого, зардлаар бүртгэж тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1."Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:"4.1.3.үр ашигтай байх;" Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.1.3 Үндэслэх анхан шатны баримт материал байхгүй нэхэмжлэх зарлагын баримт нь тамга тэмдэггүй шаардлага хангахгүй мөн нярвын тайлан бүртгэл тооцоогүй бөөн дүнгээр хяналтгүй нийт 25127.2 мянган төгрөгийн материалыг худалдан авч зардал болгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.1.4 Албан томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад томилолтын хуудас, дуудах бичиггүй үндэслэх баримтгүйгээр 900.0 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах""Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д" Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан ихариуцна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Албан шаардлага

#### 3.2.1 Ажилтнуудын улирлын үр дүнгийн урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үнэлж олгодог үр дүнгийн урамшууллыг улиралд 1 удаа олгохыг 1,2,3,11 саруудад ажлыг үнэлээгүй байхад 21951.1 мянган төгрөгийг нь сараар үнэлж олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно, 3.6. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг “бүрэн хангалттай”, “хангалттай” гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгож байх арга хэмжээг авч ажиллах

#### 3.2.2 Няравын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Няравын тайлан бүртгэл тооцоо хөтлөөгүй анхан шатны баримтуудыг үдэж архивлаагүй, бараа материалын орлогыг (бичиг хэрэг, хүнс, БҮТЭЗ) гэх мэтээр бөөн дүнгээр орлогодож, норм норматив болон шаардах хуудасгүй зарцуулсан, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд бүртгэлээр тавих хяналт алдагдаж нягтлан бодогч, няравын ажлын хариуцлагагүй байдал газар авсан. Бараа материалыг тухайн орлого авсан бөөн дүнгээр зарлагадсан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн болон дотоодын хяналт шалгалт хийдэггүй нийт 37356.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2022 оны Бараа материалын тайланг анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, няравын тайланг 2023 оны 04 сарын 01 дотор дахин шалгуулах албан шаардлага хүргүүллээ.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.3.1. Цалингийн журналын бичилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооцоолсон цалин болон суутгалууд, гарт олгох цалингийн журналын бичилтийг цалингийн нэгдсэн системийн цалингийн тооцооны хүснэгтээс НДШ, ХХОАТ, ҮЭ, хамтын сан, урьдчилгаа болон бусад суутгал, гарт олгох дүн зэрэг гүйлгээнүүдийг тооцооны дансаар дамжуулахгүйгээр цалин, НДШ-ийн зардлын дансанд шууд бичилт хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.6, 3.7, 3.8, 3.9-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооцоолсон цалин болон суутгалууд, гарт олгох цалингийн журналын бичилтийг цалингийн нэгдсэн системийн цалингийн тооцооны хүснэгтээс НДШ, ХХОАТ, ҮЭ, хамтын сан, урьдчилгаа болон бусад суутгал, гарт олгох дүн зэрэг гүйлгээнүүдийг тооцооны дансаар дамжуулахгүйгээр цалин, НДШ-ийн зардлын дансанд шууд бичилтийг Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар

баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу хийж арга хэмжээг авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### **3.4 Хариуцлага тооцуулах албан шаардлага**

**3.4.1** Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй боловч Эрдэнэмандал сумын Эрүүл мэндийн төвийн дарга нягтлан бодогч, эд хариуцагч нарын хариуцлагагүй байдлын улмаас аудитын дүгнэлт гаргах хуулийн хугацаанд шаардагдах баримт материалыг бүрэн ирүүлээгүй, удаа дараа шаардуулж, шаардлага хангахгүй, бүрдэл дутуу баримт, материал ирүүлж аудитын дүгнэлт тайлан гаргах хуулийн хугацааг хоцроосон. Шилэн дансны хуулийн дагуу байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон, өмнөх жилийн өр төлбөрийн үлдэгдэл нь нотлох баримтаар нотлогдоогүй, тайлант жилийн нярвын бараа материалын тайлан нь анхан шатны баримтад тулгуурлан бэлтгэгдээгүй, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй зэрэг зөрчил илэрсэн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд ... аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасны дагуу тул тухайн албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээд байна.

### **3.5 Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал**

**3.5.1** 2021 оны жилийн эцэст "Нарийн зураа" ХХК-д 18838.6 мянган төгрөг эмийн өглөгтэй гэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж тайлагнасан боловч өр төлбөрийг 2022 онд "Бөмбөө зайсан" Хоршоонд бараа үйлчилгээний өглөг гэж шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2.албаны эрх мэдлээ хэтрүүлэх, 39.1.4.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах ...гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэж Цагдаагийн байгууллагад шилжүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэмандал сумын ЭМТ	10	114,763.6	4	36,617.2	2	59,307.8	1		1	3	1	18,838.6

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эрдэнэмандал сумын ЭМТ	0	0	-	-	1	1	-	-